



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/116

Улаанбаатар хот

Зааварт оруулсан өөрчлөлтийг батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Цаг уурын ажиглалт, хэмжлийн технологийн заавар" ШЗ.И.01.03.2014, Цаг уурын өртөөний ажиглалтын мэдээ солилцооны АК-01 код (FM-12-SYNOP)" зааварт хавсралтаар өөрчлөлт оруулан баталсугай.

2. Өөрчлөлт орсон заавруудыг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга нарт, холбогдох заавар, зөвлөмжөөр хангаж ажиллахыг Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн (Г.Сарантуяа)-д тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын сүлжээний газар (Д.Уламбаяр)-т даалгасугай.


ДАРГА



Э.БАТТУЛГА

1526010477

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын
2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн
А/116 дүгээр тушаалын хавсралт



Зааварт оруулсан нэмэлт өөрчлөлт, засварууд

“Цаг уурын ажиглалт, хэмжлийн технологийн заавар Ш3.ИИ.01.03.2014”, “Цаг уурын өртөөний ажиглалтын мэдээ солилцооны АК-01 код (FM-12-SYNOP)” зааварт дараах нэмэлт өөрчлөлт, засваруудыг оруулж байна.

1. Хялмаа үзэгдлийг кодлох тухай

Сүүлийн 1 цагийн хугацаанд хялмаа ажиглагдсан (эхэлсэн, зогссон) эсвэл өмнөх ажиглалтын хугацаанаас хойш ажиглагдсан бол нэмэлт бүлгээр /555/-ын 96176 код өгнө.

Өөр үзэгдэл ажиглагдаагүй үед 7 дугаар бүлгийг :

- Өнгөрсөн хугацааны (W1, W2) – үүлшлийн байдлаар кодолно.
- Сүүлийн 1 цагт (WW) – үүлшлийн байдлаар кодолно.
- Ажиглалтын хугацаанд (WWW) – 76 кодолно.

2. Цан үзэгдлийг кодлох тухай

Өнгөрсөн хугацаанд (W1, W2), ажиглалтын хугацаанд болон сүүлийн 1 цагт (WW) цан ажиглагдсан бол нэмэлт бүлгээр /555/-ын 96177 код өгнө. /Тунадас гэж үзэхгүй тул тунадасны хэмжээг өгөхгүй./

Өөр үзэгдэл ажиглагдаагүй үед 7 дугаар бүлгийг:

- Өнгөрсөн хугацааны (W1, W2) – үүлшлийн байдлаар кодолно.
- Ажиглалтын хугацаа болон сүүлийн 1 цагт (WWW) – үүлшлийн байдлаар кодолно.

3. Шамарга /цасан үрэл/ үзэгдлийн тухай

“Цасан үрэл” үзэгдлийг Монгол хэлэнд “шамарга” гэж орчуулснаас шалтгаалан нойтон цас болон цас шуурах үзэгдэлтэй андуурч, буруу ажиглах тохиолдол гарч байгаа тул “цасан үрэл” гэсэн нэмэлт тайлбарыг оруулж байна. Цасан үрэл ажиглагдсан тохиолдолд дараах кодлох зарчмыг хэрэглэнэ.

- Өнгөрсөн хугацаанд (W1, W2) – туйлаадас мэтийн хатуу тунадас тул 7 кодоор өгч, тунадас өгнө.
- Ажиглалтын хугацаанд (WWW) – 77 кодоор өгч, тунадас өгнө.
- Сүүлийн 1 цагт өртөөн дээр ажиглагдсан бол (WWW) – 20 кодоор өгч, тунадас өгнө.

4. Нойтон цас үзэгдлийг кодлох тухай

“Нойтон цас” үзэгдлийг цаг уурын өртөөний ажиглалтын мэдээ солилцооны АК-01 кодоор “цастай бороо” гэж нэрлэснээс шалтгаалан “нойтон цас” болон “цастай бороо”-г тусдаа үзэгдэл гэж ойлгон, нойтон цасыг цасаар буруу кодлох тохиолдол гарч байгаа тул дараах засварыг оруулж байна.

- Өнгөрсөн хугацааны (W1, W2) – 7 кодолно.
- Сүүлийн 1 цагт өртөөн дээр (WWW) – 23 кодолно.
- Ажиглалтын хугацаанд (WWW) – 68, 69 кодолно.

5. Алсын бараатай уялдуулан үзэгдлийн эрч хүчийг дараах байдлаар үнэлнэ.

А. Униарын эрч хүч ялгаж ажиглахдаа:

- Хүчтэй: алсын бараа харагдац 1км буюу түүнээс бага байна.
- Ердийн: алсын бараа харагдац 2км нээлттэй байна.
- Сул хүчтэй: алсын барааны харагдац 4, 10 км байна. Униартай үед агаарын чийгшил их биш байна.

Б. Будангийн эрч хүч ялгаж ажиглахдаа:

- Ердийн болон сул хүчтэй буданг униартай нэгэн адил ажиглах ба 1000 метрээс бага болж хараа муудсан үед манан гэж нэрлэн ажиглах тул хүчтэй будан ажиглахгүй. Будантай үед агаарын чийгшил харьцангуй их байдгаараа униараас ялгагдана.

В. Шороон шуурга болон цасан шуурганы эрч хүч ялгаж ажиглахдаа:

Хүчтэй салхитай хамт шороон шуурга ажиглагдаж байхад алсын барааны харагдцыг 93 болон 94-р кодлоод шороон шуурганы эрч хүчийг 31 болон 32 кодолж ирүүлж байгаа нь шороон /цасан/ шуурганы аюултай үзэгдлийн критер утга болон алсын бараа, үзэгдлийн эрч хүч хоорондоо уялдахгүй байна. Алсын бараа 1000 метр буюу түүнээс бага байхад хүчтэй шороон /цасан/ шуурга, 2000, 4000 метр байхад ердийн, 10000, 20000 /нээлттэй хараа/ метр байхад сул хүчтэй шороон /цасан/ шуурга гэж ажиглана. Үүгээр 14 дүгээр зааврын 94 хуудасны шороон болон цасан эрч хүчийг алсын бараатай нь холбож ажиглах тайлбарт залруулга хийж байна.

----- ооо ООО ооо -----